

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖАРГАЛАНТ СУМЫН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/2/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Х

khovd@audit.gov.mn

Аудитын менежер:

Утас: 70432545 Цахим хаяг:

Тунгалаг бүртгэл Аудит ХХК

Аудитор: Ч.Мөнхцооз

Утас: 99028555

Цахим хаяг: munhuu8555@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт	14
Залруулсан алдаа	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ЖАРГАЛАНТ СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.УРАНБИЛЭГ ТАНАА

2021.02.19 № 4/57
Танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОДЫБААТАР

0210373

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,116,304.38</u>	<u>22,305,492.29</u>
33	АВЛАГА	1,266,134.38	17,822.29
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,266,134.38	17,822.29
35	БАРАА МАТЕРИАЛ	16,850,170.00	22,287,670.00
351	Түүхий эд материал	-	1,588,250.00
35130	Эм боох материал	-	1,588,250.00
354	Хангамжийн материал	16,850,170.00	20,699,420.00
35410	Бичиг хэргийн материал	35,000.00	35,000.00
35420	Аж ахуйн материал	309,500.00	309,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	240,000.00	240,000.00
35460	Хүнсний материал	2,392,490.00	2,626,710.00
35470	Бусад хангамжийн материал	13,873,180.00	17,488,210.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>429,581,988.28</u>	<u>411,761,606.72</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	429,581,988.28	411,761,606.72
392	Биет хөрөнгө	353,592,438.24	335,886,306.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	358,664,439.00	376,664,439.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,620,317.76)	(63,226,724.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,115,741.00	34,067,498.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,451,137.16)	(21,907,253.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,185,372.20	38,768,181.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,045,550.04)	(31,223,724.48)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,743,891.00	2,743,891.00
393	Биет бус хөрөнгө	75,989,550.04	75,875,300.08
39301	Програм хангамж	457,000.00	457,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(114,249.96)	(228,499.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	75,646,800.00	75,646,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>447,698,292.66</u>	<u>434,067,099.01</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>447,698,292.66</u>	<u>434,067,099.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	447,698,292.66	434,067,099.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,490,319.00	254,490,319.00
51101	Өмч: - төрийн	254,490,319.00	254,490,319.00
512	Хуримтлагдсан үр дүн	(208,925,195.02)	(222,221,066.67)
51210	Өмнөх үеийн үр дүн	(208,925,195.02)	(208,589,873.02)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(13,631,193.65)

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	402,133,168.68	401,797,846.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	447,698,292.66	434,067,099.01

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	428,461,138.20	464,680,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,223,877.20	22,911,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,223,877.20	22,911,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,295,786.20	22,911,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,065,786.20	22,911,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	410,237,261.00	441,769,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,240,000.00	373,894,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	317,240,000.00	373,894,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,290,100.00	67,875,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,580,900.00	67,875,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	414,035,245.58	476,908,223.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	414,035,245.58	476,908,223.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411,828,084.58	452,535,707.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,218,048.40	298,068,123.00
210101	Үндсэн цалин	204,539,285.40	248,341,539.09
210102	Нэмэгдэл	7,646,874.00	43,060,179.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,280,000.00
210104	Урамшуулал	18,031,889.00	4,386,404.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,503,141.22	36,504,777.09
210201	Тэтгэврийн даатгал	19,369,048.88	25,476,713.63
210202	Тэтгэмжийн даатгал	2,295,241.01	2,997,260.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,836,192.81	2,397,808.33
210204	Ажилгүйдлийн даатгал	454,787.14	512,090.43
210205	Эрүүл мэндийн даатгал	4,547,871.38	5,120,904.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,121,900.00	49,840,279.00
210301	Гэрэл, цахилгаан	4,446,972.00	2,480,099.00
210302	Түлш, халаалт	38,709,000.00	37,026,000.00
210303	Цэвэр, бохир ус	9,965,928.00	10,334,180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,275,323.00	1,209,178.00
210401	Бичиг хэрэг	479,000.00	216,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	237,066.00	96,778.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	197,000.00	215,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	362,257.00	425,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	255,500.00
2105	Нормативт зардал	55,554,460.00	24,461,510.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000.00	738,550.00

210502	Хоол, хүнс	54,883,960.00	23,062,960.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	610,500.00	660,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,215,000.00	1,639,300.00
210604	Урсгал засвар	2,215,000.00	1,639,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	476,000.00	532,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,000.00	100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,400,211.96	40,280,540.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	928,118.00	961,159.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,472,093.96	39,319,381.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,207,161.00	24,372,516.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	24,372,516.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24,372,516.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>14,425,892.62</u>	<u>(12,227,523.65)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>14,425,892.62</u>	<u>(12,227,523.65)</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>410,467,261.00</u>	<u>441,769,200.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>410,237,261.00</u>	<u>441,769,200.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,240,000.00	373,894,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	317,240,000.00	373,894,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,290,100.00	67,875,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,580,900.00	67,875,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>377,758,061.00</u>	<u>441,769,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>377,758,061.00</u>	<u>441,769,200.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>375,550,900.00</u>	<u>417,396,684.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,816,356.00	296,293,300.00
210101	Үндсэн цалин	164,250,900.00	176,782,156.02
210102	Нэмэгдэл	53,487,856.00	96,588,686.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,627,013.00
210104	Урамшуулал	13,077,600.00	20,295,444.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,908,644.00	37,054,488.00

210201	Тэтгэврийн даатгал	17,405,100.00	25,202,588.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,142,200.00	2,963,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,636,544.00	2,370,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	429,500.00	628,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,295,300.00	5,889,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,974,800.00	49,840,279.00
210301	Гэрэл, цахилгаан	4,446,972.00	2,480,099.00
210302	Түлш, халаалт	38,709,000.00	37,026,000.00
210303	Цэвэр, бохир ус	9,818,828.00	10,334,180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,135,800.00	4,778,237.00
210401	Бичиг хэрэг	213,237.00	529,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	211,306.00	211,937.00
210404	Ном, хэвлэл	5,700.00	6,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	209,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,557.00	3,822,100.00
2105	Нормативт зардал	57,394,300.00	26,503,080.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,000.00	2,064,800.00
210502	Хоол, хүнс	56,699,400.00	23,319,180.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	630,900.00	1,119,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,174,100.00	1,639,300.00
210604	Урсгал засвар	3,174,100.00	1,639,300.00
2107	Томилолт, зочны зардал	157,000.00	144,000.00
210702	Дотоод албан томилолт	157,000.00	144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,100.00	988,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,100.00	556,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,424,800.00	156,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,424,800.00	156,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,207,161.00	24,372,516.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	24,372,516.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24,372,516.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,490,319.00	402,133,168.68	(189,713,796.64)		466,909,691.04
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,490,319.00	402,133,168.68	(189,713,796.64)	-	466,909,691.04
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(19,211,398.38)		(19,211,398.38)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,490,319.00	402,133,168.68	(208,925,195.02)	-	447,698,292.66
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	254,490,319.00	402,133,168.68	(208,925,195.02)	-	447,698,292.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	335,322.00		335,322.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,490,319.00	402,133,168.68	(208,589,873.02)	-	448,033,614.66
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(335,322.00)	-		(335,322.00)
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	(1,403,670.00)		(1,403,670.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,227,523.65)		(12,227,523.65)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,490,319.00	401,797,846.68	(222,221,066.67)	-	434,067,099.01

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441769200.00	417396685.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441769200.00	417396685.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441769200.00	417396685.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296293300.00	296293300.0
210101	Үндсэн цалин	177213600.00	176782156.0
210102	Нэмэгдэл	97003800.00	96588687.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2211900.00	2627013.0
210104	Урамшуулал	19864000.00	20295444.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39999800.00	37054488.0
210201	Тэтгэврийн даатгал	28147900.00	25202588.0
210202	Тэтгэмжийн даатгал	2963100.00	2963100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2370400.00	2370400.0
210204	Ажилгүйдлийн даатгал	592600.00	628800.0

210205	Эрүүл мэндийн даатгал	5925800.00	5889600.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66235900.00	53290279.0
210301	Гэрэл, цахилгаан	4363100.00	2480099.0
210302	Түлш, халаалт	49370800.00	40476000.0
210303	Цэвэр, бохир ус	12502000.00	10334180.0
2104	Хангамж, бараа материалын зардал	565200.00	1005437.0
210401	Бичиг хэрэг	119500.00	185400.0
210402	Тээвэр, шатахуун	61700.00	22000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	98,100.00	211937.0
210404	Ном, хэвлэл	68,300.00	59000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	95000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	217,600.00	432100.0
2105	Нормативт зардал	35,150,400.00	26737080.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,432,000.00	2298800.0
210502	Хоол, хүнс	31,732,500.00	23319180.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	985,900.00	1119100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,639,300.00	1639300.0
210604	Урсгал засвар	1,639,300.00	1639300.0
2107	Томилолт, зочны зардал	123,700.00	1.0
210702	Дотоод албан томилолт	123,700.00	1.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575,600.00	544000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	112000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,186,000.00	832800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,186,000.00	832800.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441,769,200.00	417396684.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	373,894,000.00	349521484.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373,894,000.00	349521484.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67,875,200.00	67875200.0
132001	Орон нутгийн төсвөөс	67,875,200.00	67875200.0

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэмэлт санхүүжилт байхгүй

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Ц.Уранбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, төсвийн зардлыг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 18-наас 2021 оны 01 дугаар сарын 22-ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцооз аудитор Ч.Эрдэнэчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Багш бүр хичээл сургалтыг чанартай зааж, эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тоглоомоор дамжуулан хүүхдийг хөгжүүлж төлөвшүүлэхийг үндсэн зорилгоо болгон ажиллажээ.

2020 оны хичээл сургалтын үйл ажиллагаанд заах аргын нэгдэл, баг хамт олны бэлтгэлийг чанар үр дүнтэйгээр зохион байгуулж өдөр тутмын хичээл сургалт, хүүхэд хөгжүүлэлтийг чанарын өндөр түвшинд зохион байгуулж зорилтын дор дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хичээл сургалтын үйл ажиллагаанд багшийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн"Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд ажлын байрандаа хөгжих, чадваржих боломжийг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигтэй болох, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэн, "Авьяас", "Номын гэгээ", "Хүүхэд бүр цэцэрлэгт" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хүүхдийн хөгжлийг дэмжих
- Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжин ажиллах гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай"
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот "бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот "Хоолны зардлын норматив тогтоох тухай"

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна. Мөн тус газраас Шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах х арга хэмжээ авагдаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 478311,8 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 4783,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21798.5 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын болон үндсэн хөрөнгийн дансдуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,266,134	17,822	-1,248,312
Бараа материал	16,850,170	22,287,670	5,437,500
Үндсэн хөрөнгө	429,581,988	411,761,607	-17,820,382
Нийт хөрөнгө	447,698,293	434,067,099	-13,631,194
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	447,698,293	434,067,099	-13,631,194
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	447,698,293	434,067,099	-13,631,194

/төгрөг/

Мөнгөн хөрөнгө үлдэгдэлгүй, авлага дансны үлдэгдэл 1248,3 мянган төгрөгөөр буурсан нь шимтгэл төлөгчийн код буруу сонгосноос хамаарч шимтгэл илүү төлснөөс үүссэн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал данс 5437.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь цар тахалтай холбоотой ариутгах бодис маск, хамгаалах хувцас зэргийн үлдэгдэл 1588,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон утаанаас хамгаалах зориулалтаар 3390,0 мянган төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг цонхонд агаар шүүгч суулгасантай холбоотой байна.

Тайваны хүүхдийг ивээх сангаас үнэ төлбөргүйгээр хөнжил 25, гудас 25, углаа дэвсээ даавуу 25 ширхэг нийт 1412,5 мянган төгрөгийн үнийн дүн бүхий бараа материал нийлүүлснийг орлогод авч данс бүртгэлд тусгажээ. Аймгийн засаг даргын захирамжаар 380,0 мянган төгрөгийг маскийн үнэнд шилжүүлснийг бараа материалын данс дамжуулан хөндий орлого авч зардалд бүртгэжээ. Үүнийг аймгийн нэгдсэн тайлангаар тусгайлан авч үзэхээр болсон болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17820,3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилийн элэгдлийн 39319,3 мянган төгрөг ихээхэн нөлөө үзүүлж байгаа боловч аймгийн БСУГ-аас хөрөнгө оруулалтаар бэлтгэн нийлүүлсэн зөөврийн компьютер 2 ширхэг, 3499,0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч данс бүртгэлд тусгажээ.

Аймгийн хөрөнгө оруулалтаар тус цэцэрлэгийн арга зүйч, нягтлан эд хариуцагчийн өрөөний 18,0 сая төгрөгийн нийн дүн бүхий засварын ажлыг Элбэг гүн ХХК гүйцэтгэснийг барилгын үнийн дүнг нэмэгдүүлэн бүртгэн тайлагнасан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 279 тоот тушаалаар 13 нэрийн 11152.4 мянган төгрөгийн үнийн дүн бүхий тоног төхөөрөмж, Жаргалант сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 210 тоот тогтоолоор 42 нэрийн 8011,9 мянган төгрөгийн тавилга эд хогшил актлах шийдвэр гаргаж данснаас хассан боловч дахин үнэлгээний хэрэгжилтийг тооцож бүртгээгүй байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/23 тоот тушаалаар 21 нэрийн 1403,6 мянган төгрөгийн бараа материал хангамжийн зүйлийг актлах шийдвэр гарч данснаас хассан боловч төсвийн зардалд бүртгэн тайлагнасан байна.

Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн нийт орлого өмнөх оноос 56654,0 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн байна.

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Улсын төсвөөс олгосон санхүүжилт	317,240,000	373,894,000	56,654,000
Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт	89,290,100	67,875,200	(21,414,900)
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө	17,065,786	22,911,500	5,845,714
Үйл ажиллагааны орлогын дүн	423,595,886	464,680,700	41,084,814

Өмнөх оны үзүүлэлтээс 1 эмчийн орон тоо нэмэгдсэнтэй холбоотой цалингийн зардал нэмэгдсэн болон Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл хийгдсэнтэй холбоотойгоор санхүүжилт нэмэгдэж санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ	258,721,189	334,572,900	75,851,711
Байр ашиглалттай холбоотой зардал	53,121,900	49,900,279	(3,221,621)
Хангамж бараа материалын зардал	1,275,323	2,552,848	1,277,525
нормативт зардал	55,554,460	24,461,510	(31,092,950)

Бусад бараа үйлчилгээний зардал	43,155,212	42,451,841	(703,371)
бусад урсгал шилжүүлэг	2,207,161	24,372,516	22,165,355
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	414,035,245	478,311,894	64,276,649

Нийт зардал өмнөх оноос 64276.6 мянган төгрөгөөр буюу 15.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 75851.7, бусад урсгал шилжүүлэг 11575.0 мянган төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарчээ. Энэ нь халаалтын хугацаа 1 сараар хойшилсон, цаг үеийн нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсантай хамааралтай байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 489176.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 489176.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 47407.3 мянган төгрөгөөр бууруулж 441769.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн 48 арга хэмжээг санхүүжүүлэхээр 441769,2 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 373894,0. орон нутгийн төсвөөс 67875,2 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 373894,0 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 67875,2 мянган төгрөг, нийт 441769,2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 417396,7 мянган төгрөгийг зарцуулж 24372,5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлангийн хугацаанд нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй. Өмнөх онд тэтгэмжүүд, НДсангаас олгосон лист, хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж зэрэг ажил гүйлгээнүүд орсон бөгөөд энэ жил шууд тухайн ажилтны хувийн дансанд орсон байна. Тухайлбал: 2 багш хөдөө орон нутагт тасралтгүй ажилласны тэтгэмжээр 9172.5 мянган төгрөг, 1 хүн өндөр насны тэтгэвэрт гарсны 17908.0 мянган төгрөгийг тус тус олгожээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд хэрэгжүүлсэн горим сорилын дүнгээр алдаа зөрчил илэрсэнгүй.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зардлыг цаг хугацаанд нь зардал тус бүрээр үнэн зөв бүртгэж тайлагнах, хөнгөлөлт урамшууллыг хуулийн хүрээнд зөв тооцож олгох зөвлөмжийг өгсөн хэрэгжилт 90 орчим хувьтай байна. Тайлангийн хугацаанд зарим зардлууд бодитойгоор тайланд тусгагдаагүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6230,4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5508,9 мянган төгрөгийн алдааг залруулж, 721,5 мянган төгрөгийг алдаанд төлүүлэх акт тогтоож, 4 чиглэлийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн түлш халаалтын зардалд 3390,0 мянган төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг агаар шүүгчийн үнийг бүртгэн тайлагнасныг бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлсэд бүртгэн тайлагнах
- Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар акталсан 21 нэрийн 1403,6 мянган төгрөгийн бараа материалыг зардалд бүртгэснийг залруулж үр дүн дансыг бууруулах
- Аймгийн ИТХ, Жаргалант сумын Засаг даргын шийдвэрээр акталсан хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжилтийг тооцож нэмэгдлийг бууруулах

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 721.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоою.

Үүнд:

Ажиллагсадад илүү тооцож 571632 төгрөгийг олгосон, хяналтын тооллогоор дутагдсан бараа материалын үнэ 149960 төгрөгийг төлүүлэх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг авлага, төлбөрийн тооцоог хянах ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, заалттай нийцэхгүй, үнэн зөв бодий байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: нийт 721592 төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:

- а. Хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлаас 380.0 мянган төгрөгийн маскийг Буянт үйлийн шим ХХК-нд нийлүүлсэн зэрэг асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгдсэн тайланд аймгийн хэмжээнд авч үзэх шаардлагатай байна

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал.

1.1. **Илрүүлэлт:** Жилийн эцсийн тооллогыг эрхлэгчийн тушаалаар баталсан комисс тооллого хийсэн нэх боловч тооллогын бүртгэлд гарын үсэг баталгаажуулаагүй, акталсан хөрөнгө ангилж ялгаагүй агуулахад байсаар байна.

Эрсдэл: Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх журам дүрэм зөрчигдөх

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 5.1.2-д заасан иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д заасан анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна.

2.1. **Илрүүлэлт:** 2020 оны мөнгөн гүйлгээний болон орлого үр дүнгийн тайланд зардлын зүйл ангийг зөв тодорхойлж бүртгээгүйгээс тухайн зардлын дүн буруу илэрхийлэгдсэн

Эрсдэл: төсвийн гүйцэтгэлийг буруу тайлагнах

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 5.1.2-д төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг нагнасан байх гэснийг анхаарч ажиллахыг зөвлөв.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна.

3.1. **Илрүүлэлт:** Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

Эрсдэл: тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОАГ-2021/02../СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Жаргалант сумын 2 дугаар цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	агаар шүүгчийн үнийг халаалтын зардалд бүртгэн тайлагнасан	3390,0	Залруулга	Эрхлэгч Ня-бо	Ц.Уранбилэг Ч.Батцэцэг

2	Маскийн үнэнд мөнгө шилжүүлсэн боловч уг маск ирээгүй байхад бараа материал дансанд хөндий орлого авч зарлага гаргасан	380.0	Залруулга	Эрхлэгч Ня-бо	Ц.Уранбилэг Ч.Батцэцэг
3	Акталсан бараа материалыг зардалд бүртгэн тайлагнасан	1403,6	Залруулга	Эрхлэгч Ня-бо	Ц.Уранбилэг Ч.Батцэцэг
4	Акталсан үндсэн хөрөнгийн ногдох дахин үнэлгээний хэрэгжилтийг бүртгэн тайлагнах	335,3	Залруулга	Эрхлэгч Ня-бо	Ц.Уранбилэг Ч.Батцэцэг
5	Ажиллагсдад илүү цалин олгосон	571,6	Акт тогтоох	Эрхлэгч Ня-бо	Ц.Уранбилэг Ч.Батцэцэг
6	Хяналтын тооллогоо дутсан бараа материал төлүүлэх	149.9	Акт тогтоох	Эрхлэгч Ня-бо	Ц.Уранбилэг Ч.Батцэцэг
7	Жилийн эцсийн тооллогын дүнг баримтжуулж баталгаажуулаагүй	0	Зөвлөмж	Эрхлэгч Ня-бо	Ц.Уранбилэг Ч.Батцэцэг
8	Зарим ажил гүйлгээний НӨАТ-н баримт дутуу	0	Зөвлөмж	Эрхлэгч Ня-бо	Ц.Уранбилэг Ч.Батцэцэг
9	Санхүүгийн тайланд зардлын зүйл ангийг зарим зардлын хувьд зөв сонгоогүй	0	Зөвлөмж	Эрхлэгч Ня-бо	Ц.Уранбилэг Ч.Батцэцэг
ДҮН		6230,4			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР